



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,  
ГЕОДЕЗИ ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 04 сарын 07 өдөр

Дугаар

1/25


Улаанбаатар хот

Уралдааны удирдамж батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоолын 2.6 хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Газрын харилцааны ажилтны өдрийг угтан үйл ажиллагаагаараа тэргүүлсэн аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрыг шалгаруулах уралдааны удирдамжийг хавсралтаар баталсугай.
2. Удирдамжийн дагуу Хаягийн мэдээлэл шалгах, засварлах, зэрэгцүүлсэн хаягийн мэдээлэл үүсгэх болон хот байгуулалтын кадастрын мэдээллийн сан байгуулах ажлыг эрчимтэй зохион байгуулахыг аймгуудын Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга нарт үүрэг болгосугай.
3. Уралдааны удирдамжийг аймгуудын Газрын харилцаа, хот байгуулалтын газарт хүргүүлж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Геодези, зураг зүйн хэлтэс /Д.Мөнхцэцэг/, Хот байгуулалтын кадастрын хэлтэс /Г.Цогтсайхан/-т тус тус даалгасугай.
4. Уралдааныг дүгнэх комисс байгуулж, шалгаруулахыг Орлогч дарга А.Батбаярт даалгасугай.

ДАРГА



Ц.ГАНХҮҮ

08 200294

Газар зохион байгуулалт, геодези,  
зураг зүйн газрын даргын 2020 оны  
А/85 дугаар тушаалын хавсралт

**ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ АЖИЛТНЫ ӨДРИЙГ УГТАН ҮЙЛ АЖИЛЛАГААГААРАА  
ТЭРГҮҮЛСЭН АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН  
ГАЗРЫГ ШАЛГАРУУЛАХ УРАЛДААНЫ УДИРДАМЖ**

**НЭГ. ЗОРИЛГО**

1.1. Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоолоор батлагдсан “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам”, “Хот байгуулалтын мэдээллийн сангийн журам” -ыг хэрэгжүүлэх, Монгол Улсад хаягийн мэдээллийн систем болон хот байгуулалтын кадастрын мэдээллийн сан байгуулахад шаардлагатай өгөгдөл, мэдээллийг бэлтгэх, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2020 оны А/73 дугаар тушаалын хэрэгжилтийг эрчимжүүлэхэд уралдааны зорилго оршино.

**ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ, ХУГАЦАА**

2.1. Энэхүү уралдаанд 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /330 сумын газрын даамал/ хамрагдана.

2.2. Удирдамжийн дагуу 2020 оны 04 дүгээр сард багтааж ажлыг гүйцэтгэж, тайланг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт хүргүүлэх, 2020 оны 05 дугаар сарын 08-нд багтаан дүгнэнэ.

**ГУРАВ. УРАЛДААНЫ ХҮРЭЭНД ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ**

3.1. Уралдааны хүрээнд дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

3.1.1. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2020 оны А/73 дугаар тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу аймгийн төв болон сумдын төвд “Хаягийн мэдээлэл шалгах, засварлах, зэрэгцүүлсэн хаягийн мэдээлэл үүсгэх”,

3.1.2. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2020 оны А/73 дугаар тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу гүйцэтгэсэн ажлын тайланг 2020 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 10.00 цагт багтааж тоон байдлаар /pdf форматаар/ [info@gazar.gov.mn](mailto:info@gazar.gov.mn) хаягаар ирүүлнэ.

3.1.3. Хот байгуулалтын мэдээллийн сангийн таних тэмдэг MNS 6736:2018 стандартын дагуу dwg өргөтгөлтэй зургийн файлыг ArcGis програм ашиглан shp өргөтгөлтэй болгон хөрвүүлэх.

3.1.4 Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хөрвүүлэх ажлын явцад ХБХ, ХБКХ-ээс тогтмол аргазүйн зөвлөгөө авч, шаардлага хангасан тохиолдолд ХБКХ-т 2020 оны 05 дугаар сарын 01-ны өдөрт багтаан \\192.168.20.24\AimagIT\ХЕТ хөрвүүлэлт уралдаан хаягт байршуулан хүлээлгэн өгнө.

3.2. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар 2020 оны 05 дугаар сарын 08-нд багтаан уралдааныг дүгнэж нийтэд мэдэгдэнэ.



3.3. Шагналыг 2020 оны 05 дугаар сарын 15-ны дотор хүргүүлнэ.

### **ДӨРӨВ. УРАЛДААНЫГ ДҮГНЭХ ЖУРАМ**

4.1. Уралдаанд аймгуудын Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас ирүүлсэн, удирдамжийн дагуу гүйцэтгэсэн ажлын тайлан, мэдээллийн санд оруулсан засвар, өөрчлөлт, тэдгээрийн тоо хэмжээ /сум бүрээр/ зэргийг харгалзан үзэж дүгнэнэ.

4.2. Уралдааны эхний хэсэгт багтах Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2020 оны А/73 дугаар тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу гүйцэтгэх ажлыг дараах байдлаар дүгнэнэ. Үүнд:

4.2.1. “Хаягийн мэдээллийн сан бүрдүүлэх” сэдвийн хүрээнд нийт 100 оноо. Үүнээс:

4.2.1.1. Хаягийн мэдээллийн сан дахь гудамжны нэр, дугаар Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолтой нийцэж буй эсэхийг шалгах, засварлах – 8 оноо,

4.2.1.2. Багийн болон гудамж, зам, талбайн нэр монгол хэлнээс өөр хэл дээр бичигдсэн эсэхийг шалгах, засварлах – 8 оноо,

4.2.1.3. Хашаа, байшингийн дээр хуучин, шинэ аль хаяг суурилуулсан, эсвэл хос хаягтай эсэхийг шалгах, засварлах – 8 оноо,

4.2.1.4. Газрын кадастрын мэдээллийн сан дахь хашаа, байшингийн дугаар нь хаягийн мэдээллийн сан дахь хашаа, байшингийн дугаартай нийцэж буй эсэхийг шалгах, засварлах – 20 оноо,

4.2.1.5. Газрын кадастрын мэдээллийн сан дахь байшингийн дугаар хаягийн мэдээллийн сан дахь байшингийн дугаарыг оруулж засварлах /барилгажсан хэсэг/ - 20 оноо,

4.2.1.6. Хаягийн мэдээллийн сангийн зураг нь газрын кадастрын мэдээллийн сангийн зурагтай давхцаж буй эсэхийг шалгах, бүртгэх - 8 оноо,

4.2.1.7. Хаягийн мэдээлэл шалгах, засварлах, зэрэгцүүлсэн хаягийн мэдээлэл үүсгэх ажлыг гүйцэтгэж байх үед хаягийн мэдээллийн санд эсвэл газрын кадастрын мэдээллийн санд хашаа, байшин дүрслэгдээгүй орхигдсон байвал нөхөж оруулах – 16 оноо,

4.2.1.8. Хашаа, байшингийн орц, гарцыг тэмдэглэж мэдээллийн санд оруулах – 12 оноо.

4.2.1.9 Ажил бүрийн үнэлгээг аймгийн төв болон сумын төвийн хаягийн мэдээллийн санд оруулсан нэгж талбарын тоог /Хавсралт/ шалгасан нэгж талбарын тоотой харьцуулан, газрын кадастрын мэдээллийн санд хаягийн мэдээлэл бүрэн орсон эсэхээр тооцож гаргана.

4.3. Уралдааны 2 дахь хэсгийн “Хот, тосгон, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний файл хөрвүүлэх” ажлыг дараах байдлаар дүгнэнэ.

4.3.1. “Хот, тосгон, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний файл хөрвүүлэх” ажил нь нийт 100 оноотой. Үүнээс:

4.3.1.1 Хоёроос доошгүй Хот, тосгон, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хөрвүүлсэн - 20 оноо

4.3.1.2 Хот байгуулалтын мэдээллийн сангийн таних тэмдэг MNS 6736:2018 стандартын дагуу хөрвүүлсэн - 10 оноо

4.3.1.3 Геодезийн сүлжээнд топологийн алдаагүй хөрвүүлсэн– 10 оноо

4.3.1.4. Хот төлөвлөлтийн давхаргуудыг бүрэн хөрвүүлсэн байдал- 60 оноо. Үүнд:

- Газар зохион байгуулалт, архитектур орон зайн бүсчлэл-10 оноо
- Улаан шугам, өндөржилт, хамгаалалтын бүс – 10 оноо
- Архитектур орон зайн төлөвлөлт – 10 оноо
- Гудамж замын сүлжээ – 10 оноо
- Инженерийн дэд бүтэц, хангамж – 10 оноо
- Ногоон байгууламж, тохижилт, рекраци – 10 оноо

4.3.1.5. Заалт бүрт өгсөн оноонуудын нийлбэр дүнгээр үнэлж, үнэлгээний дунджаар байр эзлүүлнэ.

4.4. Уралдааны нэгдсэн байрыг шалгаруулахдаа энэхүү удирдамжийн 4.2.1-д заасан “Хаягийн мэдээллийн сан бүрдүүлэх” ажлын үнэлгээг 70 хувиар, 4.3.1-д заасан “Хот, тосгон, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний файл хөрвүүлэх” ажлын үнэлгээг 30 хувиар тооцно.

4.5. Энэхүү удирдамжийн 4.4-д заасан үнэлгээний нийт дүнгээр аймгуудын Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын үйл ажиллагааг үнэлж, дараах байдлаар шалгаруулна. Үүнд:

- 1 дүгээр байр – 1,
- 2 дугаар байр – 1,
- 3 дугаар байр – 1,
- 4 дүгээр байр – 2.

## ТАВ. ШАГНАЛ

5.1. Уралдаанд шалгарсан аймгуудын Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрыг дараах мөнгөн шагналаар шагнаж урамшуулна. Үүнд:

д/д	Эзлэх байр	Шагналын хэмжээ /төгрөг/	Тоо хэмжээ	Нийт дүн
1	1 дүгээр байр	3,500,000	1	3,500,000
2	2 дугаар байр	2,500,000	1	2,500,000
3	3 дугаар байр	2,000,000	1	2,000,000
4	4 дүгээр байр	1,000,000	2	2,000,000
	Бүгд дүн			10,000,000

## Уралдааны удирдамжийн хавсралт

2020 оны А/73 дугаар тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу аймгийн төв болон сумдын төвд “Хаягийн мэдээлэл шалгах, засварлах, зэрэгцүүлсэн хаягийн мэдээлэл үүсгэх” ажлын хүрээнд шалгах, засварлах барилга, хашааны тоо хэмжээ /аймгийн хэмжээнд/

д/д	Аймгийн нэр	Барилга	Хашаа
1	Архангай	15805	15873
2	Баян-Өлгий	27324	12050
3	Баянхонгор	7242	11828
4	Булган	16352	11784
5	Дархан-Уул	13197	12447
6	Дорнод	13292	17181
7	Дорноговь	13537	8035
8	Дундговь	5028	5339
9	Говь-Алтай	13835	5813
10	Говь-Сүмбэр	2387	3739
11	Хэнтий	13117	13257
12	Ховд	17674	10584
13	Хөвсгөл	27110	23946
14	Орхон	16816	18421
15	Сэлэнгэ	23442	22819
16	Сүхбаатар	7801	8876
17	Төв	13955	19439
18	Өмнөговь	7024	16448
19	Увс	16638	13744
20	Өвөрхангай	14364	21129
21	Завхан	14020	12519
<b>Нийт</b>		<b>299960</b>	<b>285271</b>